



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/1272

Улаанбаатар хот

Барилга акталж, данснаас
хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Барилга акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай” 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 108 дугаар цэцэрлэгийн балансад бүртгэлтэй, нийт 637,727,135.00 (зургаан зуун гучин долоон сая долоон зуун хорин долоон мянга нэг зуун гучин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ, 501,474,659.08 (таван зуун нэг сая дөрвөн зуун далан дөрвөн мянга зургаан зуун тавин есөн төгрөг найман мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан цэцэрлэгийн хуучин барилгыг акталж, данс бүртгэлээс хасахыг Чингэлтэй дүүргийн 108 дугаар цэцэрлэг (Ц.Цэндсүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасах барилгыг нурааж буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3.Барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой эд хөрөнгийг худалдан борлуулж 13,802,200.00 (арван гурван сая найман зуун хоёр мянга хоёр зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Чингэлтэй дүүргийн 108 дугаар цэцэрлэг (Ц.Цэндсүрэн), орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110205560

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 22 дугаар сарын 04 өдрийн
 2024.03.04 дугаар захирамжийн
 хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Цэцэрлэгийн барилга /хоёр давхар/	1986	Чингэлтэй дүүрэг 6 дугаар хороо	606,105,205.00	118,347,104.88	487,758,100.12	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02.07. 081/146 дугаар дүгнэлт
2	Бохирын шугам	1986		6,243,250.00	5,722,979.46	520,270.54	
3	Цахилгааны шугам	1986		328,000.00	328,000.00	0.00	
4	Тоглоомын талбай	1986		4,920,225.00	4,920,225.00	0.00	
5	Бетон хучилттай явган зам, талбай	1986		4,794,225.00	4,394,706.36	399,518.64	
6	Шигтгэмэл хавтан хучилттай явган зам, талбай	2011		8,310,960.00	2,539,460.22	5,771,499.78	
7	Бут, сөөг	2018		4,615,500.00	-	4,615,500.00	
8	Шилмүүст мод	2018		1,992,570.00	-	1,992,570.00	
9	Навчит мод	2018		417,200.00	-	417,200.00	
Нийт дүн				637,727,135.00	136,252,475.92	501,474,659.08	